



Арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчим ба тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн этгээд (БЭБХЭ)-ийн чиг үүргийн харилцан хамаарал

Лувсанбатын ЖАВХЛАНТ*

I. Удиртгал

II. Үндсэн хэсэг

1. Арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчмын ойлголт, үндсэн шинжүүд
2. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт дахь итгэлийг хамгаалах зарчим
3. Харьцуулсан судалгаа
4. Тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн этгээдийн чиг үүрэг болон итгэлийг хамгаалах зарчимтай холбоотой асуудал

III. Дүгнэлт



* Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн Захиргааны эрх зүйн секторын судлаач, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрант.



Арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчим ба тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн этгээд (БЭБХЭ)-ийн чиг үүргийн харилцан хамаарал

Лувсанбатын ЖАВХЛАНТ Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн Захиргааны эрх зүйн секторын судлаач, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрант.

Хураангуй: Энэхүү өгүүллийн хүрээнд гүйцэтгэх удирдлагын компанийг төлөөлж хэлцэл хийх бүрэн эрхэд хийсэн хязгаарлалтын талаар болон түүнийг компанийг төлөөлөх бүрэн эрхтэй гэж итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахтай холбоотой онолын үзэл баримтлалыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахыг зорьсон болно. Ингэхдээ гуравдагч этгээд гэх ерөнхий ойлголтыг нарийвчилж, банк, эрх бүхий хуулийн этгээдийн хуульд заасан чиг үүрэг нь итгэлийг хамгаалах зарчимтай зөрчилдөх эсэх талаар судалсан болно.

Учир нь Банк, эрх бүхий хуулийн этгээд нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд харилцагчийн талаар мэдээллийг цуглуулах бүрэн эрхтэй байдаг тул илэрхий бүрэн эрхийн онолын үндсэн шинжийг хангахгүй байх боломжтой байна.

Түлхүүр үг

Илэрхий бүрэн эрхийн онол, гүйцэтгэх удирдлага, бүрэн эрхийн хязгаарлалт, банк, эрх бүхий хуулийн этгээд.

I. УДИРТГАЛ

Компанийн тухай хууль¹ (цаашид "КТХ" гэх)-ийн 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэгт "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна" гэж заасны дагуу гүйцэтгэх удирдлага нь компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй хэдий ч энэ эрхийг хууль тогтоомж болон компанийн дүрэм, гэрээ, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хязгаарлах боломжтой юм.

Энэхүү өгүүллийн хүрээнд гүйцэтгэх удирдлагын компанийг төлөөлөх бүрэн эрхийн хязгаарлалтыг дотоод хязгаарлалт болон гадаад хязгаарлалт²

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №142.

² Тус өгүүллийн хүрээнд гүйцэтгэх удирдлага компанийг төлөөлөх бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхийг компанийн дотоод баримт бичгийн хүрээнд бус хуульд заасны дагуу хязгаарласан байхыг ойлгох тул "гадаад хязгаарлалт" гэх нэршлийг ашигласан болно.

гэж ангилсан бөгөөд гадаад хязгаарлалттай холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар судаллаа. Гадаад хязгаарлалт гэдэгт хуульд заасны дагуу гүйцэтгэх удирдлага компанийг төлөөлөх бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэх эрхийг нь хязгаарласан байхыг ойлгоно. Үүнд КТХ-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хамаарах ба тус хэлцлийг байгуулах журмыг хуульд тодорхой заасан байна. Тодруулбал, гүйцэтгэх удирдлага нь сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийг бие даан хийх эрхгүй бөгөөд компанийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн хэлцэл хийх зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн, тэдгээрийн оролцоотойгоор тус хэлцлийг хийхээр хуульчилсан.

Харин гүйцэтгэх удирдлага нь дээрх хэлцэл хийх журмыг баримтлаагүй, ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр бусад этгээдтэй сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэлд тооцогдох хэлцэл хийсэн бол тухайн хэлцэл нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасны дагуу *"зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн"* хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцогдоно. Хүчин төгөлдөр бус байх хэлцэл болон түүнд үндэслэн хийсэн хэлцлүүд нь хийсэн цагаасаа хүчин төгөлдөр бус байдаг³. Улсын Дээд шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн "Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 17 дугаар тогтоолын⁴ 5.5 дахь хэсэгт ИХ-ийн §56.1.8-д заасан *"зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл"* гэдгийг тайлбарлахдаа *"...тухайн хэлцлийг хийхэд тодорхой этгээдийн зөвшөөрлийг авах хуулиар тогтоосон шаардлага зөрчигдсөн байхыг ойлгох бөгөөд уг хэлцэлд хуулийн 50 дугаар зүйлийн зохицуулалт хамаарна"* гэжээ.

Энэ тохиолдолд түүнд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах шаардлага үүснэ. Харин тусгайлсан зохицуулалт бүхий гуравдагч этгээд буюу Банк, эрх бүхий хуулийн этгээдийн хувьд хуулиар харилцагчийг таньж, баталгаажуулах болон харилцагчийн бүртгэл хөтлөх чиг үүрэгтэй нь холбогдуулан мэдээлэл цуглуулах бүрэн эрхийг олгосон тул энэ бүрэн эрхийн хүрээнд итгэлийг хамгаалах зарчим хязгаарлагдах боломжтой юм.

Иймд энэхүү өгүүллээр гүйцэтгэх удирдлагын компанийг төлөөлөх бүрэн эрхийн хязгаарлалтын улмаас гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахтай холбоотой онолын үзэл баримтлал болон энэ талаар Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан талаар харьцуулан судалсны үндсэн дээр компани болон банк, эрх бүхий хуулийн этгээдийн хооронд хийсэн хэлцлийг компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхгүй байдлыг ашиглан хүчингүй болгуулах эрсдэл байгаа эсэх талаар судлахыг зорилоо.

Сэдвийн судлагдсан байдал: Арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчимтай холбоотойгоор судлаач, доктор Г.Даваанямын *"Иргэний хуулийн 65.1 дэх илэрхий бүрэн эрхийн ойлголт, түүний хэрэглээ"* сэдэвт 2023 оны "Эрх зүй" сэтгүүлийн №4 дугаарт нийтлэгдсэн өгүүлэлд илэрхий бүрэн эрхийн онолын үзэл баримтлалыг тодорхойлж, Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалт,

³ Даваасүрэнгийн Наранчимэг, Иргэний эрх зүй – I суралцах бичиг, (Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр, 2023), 121-122 дахь тал.

⁴ Улсын дээд шүүхийн 2010 оны 06 сарын 22-ны өдрийн 17 тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16468170319731>, (Сүүлд үзсэн: 2026.05.12).



түүний хэрэгжилттэй харьцуулан дүн шинжилгээ хийсэн байна. Мөн тус судлаачийн "Гүйцэтгэх удирдлагын итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхэд хийсэн дотоод хязгаарлалт, түүний эрх зүйн үр дагавар" сэдэвт 2022 оны "Эрх зүй" сэтгүүлийн №3 дугаарт нийтлэгдсэн өгүүлэлд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг компанийн дотоод зохион байгуулалтын хүрээнд хязгаарласантай холбоотой асуудалд дүн шинжилгээ хийжээ. Харин энэхүү өгүүлэлд тухайн судлаачийн бүтээлд дурдсан гүйцэтгэх удирдлагын компанийг төлөөлөх бүрэн эрхэд хийсэн дотоод хязгаарлалтыг бус хуульд заасан /гадаад/ хязгаарлалтын хүрээнд судлахыг зорьсон.

Мөн судлаач, доктор Т.Мэндсайханы "Гэрээний эрх зүй" номын 3-р бүлэг, судлаач, доктор Г.Даваанямын "Компанийн эрх зүйн онол, практик" номын 2025 оны хэвлэлийн 5 дахь хэсгийн 2-р бүлэг, судлаач, профессор Очи-Ай Сэйчигийн "Компанийн эрх зүйн үндсэн ойлголт" номын орчуулгын 5-р бүлэгт тус тус арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчмын ерөнхий ойлголтын талаар дурджээ.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Хувийн эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчмыг эд хөрөнгийн эрх зүй болон арилжааны эрх зүйн хүрээнд гэж зааглах боломжтой бөгөөд энэхүү өгүүллийн хүрээнд гүйцэтгэх удирдлага компанийг төлөөлж хэлцэл хийх бүрэн эрхийн асуудал болон тухайн хэлцлийн хүчин төгөлдөр бус байдлын улмаас гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахтай холбоотой асуудлыг хөндөхийг зорьсон тул эд хөрөнгийн эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчимтай холбоотой агуулгыг дэлгэрүүлж судлаагүй болно.

1. Арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчмын ойлголт, үндсэн шинжүүд

Арилжааны эрх зүйн хүрээнд компани үйл ажиллагаагаа явуулахдаа бусадтай олон төрлийн эрх зүйн харилцаанд ордог бөгөөд энэхүү эрх зүйн харилцааны нэг томоохон хэсэг нь бусадтай хийсэн гэрээ, хэлцэл байна.⁵ Тухайн хэлцлийг компанийг төлөөлөх эрх бүхий этгээд хийх бөгөөд хэрэв компанийг төлөөлж хэлцэл хийх эрхгүй этгээд хэлцэл хийсэн тохиолдолд уг хэлцэл хүчин төгөлдөр бус болох эрсдэлтэй.

*Компани нь хуулийн этгээд болохын хувьд хиймэл, хуулиар бий болгосон биегүй этгээд юм. Тийм учраас компани нь ямарваа нэг үйлдлийг хийхдээ зөвхөн өөрийн төлөөлөгчөөр дамжуулан тэрхүү үйлдлээ илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, компани төлөөлөгчөөр дамжуулахгүй бол үйлдэл хийх боломжгүй юм.*⁶

⁵ Ганхуягийн Давааням, *Компанийн эрх зүйн онол, практик*, (Улаанбаатар: Соёмбо принтинг, 2025), 240 дэх тал.

⁶ Батболдын Амарсанаа, *Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал*, (Улаанбаатар: 2012), 27 дахь тал.



КТХ-ийн 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэгт заасны дагуу компанийг ихэвчлэн гүйцэтгэх удирдлага нь итгэмжлэлгүйгээр төлөөлдөг⁷ бөгөөд хэрэв бусад этгээд компанийг төлөөлөх бол эрх бүхий этгээдийн олгосон итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлнө. Харин гүйцэтгэх удирдлагын компанийг төлөөлөх бүрэн эрхийг хууль тогтоомж болон компанийн дүрэм, эрх бүхий этгээд /ТУЗ, хувьцаа эзэмшигч, захиргаа г.м/-ийн шийдвэр, гэрээ зэргээр хязгаарласан байх боломжтой. Иймд тухайн төлөөлж буй этгээдийн компанийг төлөөлж хэлцэл хийх эрх нь хязгаарлагдсан этгээд өөр бусад этгээд /гуравдагч этгээд/-тэй хэлцэл хийсэн тохиолдолд тухайн хэлцлийн хүчин төгөлдөр байдлаас шалтгаалж тухайн төлөөлж буй этгээдэд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн итгэл хэрхэн хамгаалагдах талаар асуудал үүснэ. Үүнтэй холбоотойгоор төлөөллийн харилцаан дахь гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах талаар онолын ойлголтыг тодруулах шаардлага үүсэж байна.

Гэрээний эрх зүйн үүднээс төлөөлөх бүрэн эрх олж авсан этгээдийн гаргаж байгаа үг хэллэг, үйлдэл нь гуравдагч этгээдийн хувьд ойлгогдохуйц хангалттай нөхцөл байгаа тохиолдолд түүнийг төлөөлөгчийг төлөөлөх бүрэн эрхтэй гэж үзэх юм.⁸

Компанийн төлөөлөлтэй холбоотой хүлцсэн бүрэн эрх (англ. *tolerated authority*), илэрхий бүрэн эрх (англ. *Apparent authority*) гэх 2 онолын ойлголт байна.⁹ Энэхүү 2 ойлголтын аль аль нь гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахад чиглэдэг хэдий ч төлөөлүүлэгчээс шалтгаалж харилцан адилгүй агуулгыг илэрхийлж байна. Тодруулбал, хүлцсэн бүрэн эрхийн хүрээнд төлөөлүүлэгч төлөөлж буй этгээдийг өөрийг нь төлөөлж байгаа талаар мэдсэн хэдий ч түүнийг төлөөлөх эрхгүй талаар гуравдагч этгээдэд мэдэгдээгүй буюу эс үйлдэхүй гаргасан гэх агуулгыг илэрхийлдэг. Харин илэрхий бүрэн эрхийн ойлголт нь төлөөлүүлэгч өөрөө төлөөлж буй этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй гэх ойлголтыг гуравдагч этгээдэд өгөхөөр нөхцөл байдал бүрдүүлсэн байхыг ойлгохоор байна.¹⁰ Хүлцсэн бүрэн эрхийн ойлголт нь тус өгүүллийн агуулгад шууд хамааралгүй байх тул цаашид илэрхий бүрэн эрхтэй холбоотой агуулгыг дэлгэрүүлэн судлах болно.

Илэрхий бүрэн эрхийн талаарх онолын ойлголт нь XVIII-XIX зууны үеэс эхлэн АНУ-ын шүүхийн практикаас үүсэж, хөгжсөн гэж үздэг.¹¹ Тус онолын чиг үүрэг нь төлөөлөгч нь төлөөлүүлж буй этгээдийн зөвшөөрөлгүйгээр хэлцэл хийсэн боловч түүнтэй хэлцэл хийсэн гуравдагч этгээд тухайн төлөөлөгчийг хэлцэл хийх бүрэн эрхтэй байсан гэж итгэсэн тохиолдолд түүний итгэлийг хамгаалахад

⁷ Хууль тогтоомж болон компанийн дүрэм, гэрээгээр зохицуулсан тохиолдолд зарим төрлийн харилцаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас бусад эрх бүхий этгээд (хувьцаа эзэмшигч, ТУЗ г.м) компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх боломжтой.

⁸ Жаргалсайханы Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй II – Гэрээний эрх зүй*, (Улаанбаатар: Адмон Принт, 2022), 118 дахь тал.

⁹ Ганхуягийн Давааням, "Иргэний хуулийн 65.1 дэх илэрхий бүрэн эрхийн ойлголт, түүний хэрэглээ", *Эрх зүй* 64 (4), 2023, 126 дахь тал.

¹⁰ Мөн тэнд.

¹¹ Victoria Barnes and James Oldham, "The Legal Foundations of Apparent authority", *Journal of Corporation law* 44, no4 (Jul 2018), 650, <https://pure.qub.ac.uk/en/publications/the-legal-foundations-of-apparent-authority/> (last visited May.14, 2026).



оршино.¹² Тодруулбал, төлөөлүүлж буй этгээд хэлцэлд төлөөлж буй этгээдийг тухайн хэлцлийг хийх эрхтэй гэж ойлгохоор нөхцөл байдлыг үүсгэсэн бол түүнд итгэсэн гуравдагч этгээд хохирох ёсгүй гэх агуулгаар тайлбарлаж болохоор байна.

Мөн төлөөлж буй этгээд нь төлөөлүүлж буй этгээдийн өмнөөс үйлдэл /хэлцэл/ хийх эрхгүй, эсхүл тухайн эрхээ хэтрүүлсэн байх боломжтой юм.¹³ Товчхондоо илэрхий бүрэн эрх гэдэг нь төлөөлөгчийн эрх мэдэл бусдад хэрхэн харагдаж байгаа явдлыг хэлэх юм.¹⁴

Энэхүү онол нь (1) гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах, (2) гадаад нөхцөл байдлын улмаас үүссэн эрсдэл /хариуцлага/-ийг хариуцах этгээдийг тодорхойлох, (3) эрх зүйн харилцааны тогтвортой байдлыг хангахад чиглэдэг.¹⁵

Илэрхий бүрэн эрхийн онолын үндсэн бүрэлдэхүүн хэсгийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

Хүснэгт 1. Илэрхий бүрэн эрхийн онолын үндсэн шинжүүд¹⁶

№	Үндсэн шинж	Тайлбар
	Объектив гадаад илэрхийлэл	Тодорхой эрх зүйн чадвар буюу бүрэн эрх байгаа гэсэн дүр төрх бүрдсэн.
	Шинж чанар	Гаднах шинж нь тухайн этгээдийн үйлдэл, зохион байгуулалт, эсхүл үйл ажиллагааны хүрээнээс шалтгаалсан.
	Итгэл дээр тулгуурласан үйлдэл	Гуравдагч этгээд тухайн гадаад шинжид итгэн, эрх зүйн ач холбогдол бүхий шийдвэр /үйлдэл/ гаргасан.
	Шалтгаан	Тухайн шийдвэрийг гаргахад гадаад илэрхийлэл нөлөөлсөн байх.
	Сайн санаа (гер. Guter Glaube, англ. Good faith)	Гуравдагч этгээд бодит байдлыг мэдээгүй бөгөөд түүнд анхаарал хандуулсан (гер. zumutbare Sorgfal) ч мэдэх боломжгүй байсан.
	Хамгаалах ач холбогдол	Тухайн итгэл нь өөрийн шинж чанар болон холбогдох эрх зүйн зохицуулалтын хүрээнд хамгаалагдахуйц байх.

Дээрх шинжүүд бүрдсэн тохиолдолд гадаад илэрхийллийг хамгаалах онолын хүрээнд гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах үндэслэл болно.

Сайн санааны үүднээс хэлцэлд итгэсэн байх шинж нь гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахад гол хязгаарлалт болдог. Тодруулбал, гуравдагч этгээд нь хэлцэлд шударгаар итгэсэн, бодит нөхцөл байдлыг мэдээгүй тохиолдолд түүний итгэлийг хамгаалах үндэслэл болох юм. Харин гуравдагч этгээд нь бодит нөхцөл байдлыг мэдэх боломжтой байсан хэдий ч хайхрамжгүй хандсан, илэрхий нөхцөл байдлыг үл тоосон бол түүнийг сайн санааны үүднээс хандсан буюу шударга итгэл үнэмшилтэй байсан гэж үзэхгүй.¹⁷

¹² Ibid 649.

¹³ Carole Murray, David Holloway and Daren Timson-Hunt, *Schmitthoff's Export Trade*, 11th ed. (William Clowes, 2007), 688.

¹⁴ Ibid.

¹⁵ MTRLegal: Rechtsscheintheorie, 2025, <https://www.mtrlegal.com/wiki/rechtsscheintheorie/>, (abgerufen am 05.11.2026).

¹⁶ Ibid.

¹⁷ Ibid.



Зарим судлаачдын үзсэнээр өмнө дурдсанчлан гуравдагч этгээд нь төлөөлөгчийг хэлцэл хийх эрхтэй эсэхийг мэдэж байсан, эсхүл нягтлан шалгах ёстой байсан бөгөөд ийнхүү нягтлан шалгаагүй тохиолдолд илэрхий бүрэн эрхийн хамгаалалтад найдах боломжгүй гэжээ.¹⁸ Өөрөөр хэлбэл, гуравдагч этгээд нь хэлцлийн нөгөө тал буюу компанийг төлөөлж буй этгээдийг хэлцэл хийх эрхтэй этгээд мөн эсэхийг тогтооход тодорхой хэмжээний хүчин чармайлт гаргасан байх ёстой гэж үзсэн байна.

Оксфордын их сургуулийн профессор Эван МакКендрик өөрийн бүтээлдээ "...компанийг огт төлөөлөх эрхгүй этгээд өөр этгээдэд өөрийгөө компанийг төлөөлөх эрхтэй мэт ойлголтыг өгсөн бол тухайн компанид үүрэг хүлээлгэх боломжгүй..." гэжээ.¹⁹ Тодруулбал, төлөөлж байгаа этгээд нь тухайн компанитай хамааралтай этгээд байх ёстой гэж Хүснэгт 1-т дурдсан гадаад илэрхийллийг хамгаалах онолын үндсэн бүрэлдэхүүн хэсгийн эхний шинж буюу "Объектив гадаад илэрхийлэл" гэх шинжийн агуулгыг дурджээ.

Харин компанийн тамга, тэмдэг, цахим гарын үсэг, албан бичиг, ажлын байршил, компанийн тогтсон практик зэрэг нь төлөөлөх бүрэн эрх байгаа мэт ойлголтыг гуравдагч этгээдэд төрүүлэх хэрэгсэл болдог²⁰ байна.

Мөн Монгол Улсын компанийн эрх зүйн судлаач, доктор Г.Давааням өөрийн бүтээлдээ "илэрхий бүрэн эрхийн ойлголт нь төлөөллийн харилцаан дахь итгэлийг хамгаалах зарчмын хүрээнд томоохон байр суурийг эзэлдэг" бөгөөд дараах урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдолд гуравдагч этгээдийн итгэл хамгаалагдана гэж үзжээ. Үүнд:²¹

- 1) Бодит байдлаас ялгаатай гадаад илэрхийлэл бүрдсэн;
- 2) Эрхийн жинхэнэ эзэмшигчээс гадаад илэрхийлэл шалтгаалсан;
- 3) Уг гадаад илэрхийлэлд гуравдагч этгээд итгэсэн /шударга байх/ гэжээ.

Үүнээс үзэхэд, дээрх 3 шинж болон Хүснэгт 1-т тодорхойлсон илэрхий бүрэн эрхийн онолын үндсэн бүрэлдэхүүнд хамаарах шинжүүд нь ижил агуулгатай байх тул арилжааны эрх зүйн хүрээнд илэрхий бүрэн эрхийн онолын ойлголт буюу гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах зарчмын талаар судлаачид нэгдмэл ойлголтод хүрсэн гэж үзэж болохоор байна.

2. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт дахь итгэлийг хамгаалах зарчим

Компани өөрийн аж ахуйн үйл ажиллагааг явуулах замаар арилжааны эрх зүйн харилцаанд оролцоходоо бусад этгээдтэй хэлцэл хийх зайлшгүй шаардлага үүсдэг бөгөөд тухайн хэлцэлд ихэвчлэн компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох гүйцэтгэх удирдлага нь компанийг төлөөлж хэлцэл хийдэг талаар өмнө дурдсан билээ. Энэ хэсгийн хүрээнд гүйцэтгэх удирдлагын компанийг төлөөлж хэлцэл хийх бүрэн эрхэд хийсэн хязгаарлалттай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд итгэлийг хамгаалах зарчим хэрхэн хэрэгжих

¹⁸ Roy Goode and Ewan McKendrick, *Commercial law*, 6th ed. (LexisNexis and Penguin Books, 2020), 233.

¹⁹ Ibid, 232.

²⁰ Ibid.

²¹ Г.Давааням, *Өмнөх эшлэл* 8, 127 дахь тал.



талаар дүн шинжилгээ хийх болно.

Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт "Нэг этгээд өөрийгөө төлөөлөх бүрэн эрхтэй гэсэн ойлголтыг нөгөө этгээдэд өгөхөөр нөхцөл бүрдүүлснээс нөгөө этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй гэж ойлгон түүнийг шударгаар төлөөлөн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бол өөрийгөө төлөөлүүлэхээр ойлголт өгсөн этгээд төлөөлсөн этгээдийн бүрэн эрхгүй байсныг ашиглаж болохгүй" гэж заасны дагуу гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахтай холбоотой суурь зохицуулалт болсон гэж үзэхээр байна. Харин тухайн зохицуулалт нь тус өгүүллийн эхний хэсэгт дурдсан хүлцсэн бүрэн эрхийн хүрээнд хамаарах бөгөөд илэрхий бүрэн эрхийн хүрээнд хэрэглэгдэх эсэх нь эргэлзээтэй юм.²²

Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн хязгаарлалтын хүрээ, зохицуулалтын ялгаатай байдлаас шалтгаалж дотоод хязгаарлалт болон гадаад хязгаарлалт гэж ангилах боломжтой байна.

Дотоод хязгаарлалт гэдэгт компани өөрийн онцлогт нийцүүлэн компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, гэрээ зэргээр гүйцэтгэх удирдлагын төлөөлөх бүрэн эрхийн хүрээг тодорхойлсон хязгаарлалтыг ойлгоно.²³ Энэхүү гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд тавьсан дотоод хязгаарлалт нь компанийн дотогш чиглэсэн харилцаанд хамаарах тул гуравдагч этгээдэд үйлчлэхгүй гэсэн суурь зарчим үйлчилнэ. Энэ нь компанийн гадагш чиглэсэн гадаад илэрхийлэлд итгэж гэрээний харилцаанд орсон гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах үзэл санаанд тулгуурладаг.²⁴

Энэ талаар КТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт "Компани эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээг дүрмээрээ хязгаарлаж болно", мөн зүйлийн 8.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 8.2-т заасны дагуу компани эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээг хязгаарласан нь уг хязгаарлалтыг мэдэхгүйгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа гуравдагч этгээдийн өмнө уг компанийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй" гэж заасны дагуу гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах зарчмыг хуульчилсан байна. Иймд гүйцэтгэх удирдлага компанийг төлөөлж гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн тохиолдолд компанийн дотоод хязгаарлалт нь тухайн тохиолдолд үйлчлэхгүй бөгөөд гуравдагч этгээдийн итгэл нь хамгаалагдана.

Гадаад хязгаарлалтад хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хязгаарласан байхыг ойлгоно. Жишээлбэл, Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцэл болон мөн хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэр дээр үндэслэж, түүний зөвшөөрлийн үндсэн дээр тус хэлцлийг хийхээр байна.

²² Мөн тэнд.

²³ Дам эшлэв: Г.Давааням, *Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт*, 2021, 89 дэх тал.

²⁴ Дам эшлэв: Г.Давааням, *2011 оны Компанийн тухай хууль дахь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ*, 2021, 47–49 дэх тал.

а. Сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүний эрх зүйн зохицуулалт

Хувийн эрх зүйн гэрээний үндсэн шинжийг (1) гэрээний талууд, (2) гэрээний агуулга ба тохиролцоо, (3) гэрээ байгуулах үндэслэл, (4) гэрээний хэлбэр зэрэг бүрдүүлбэр дээр тулгуурлан тодорхойлдог.²⁵ Харин КтХ-д сонирхлын зөрчилтэй хэлцлийн үндсэн шинжийг гэрээний талуудад тулгуурлан тодорхойлсон байна.

Тодруулбал, КтХ-ийн 89 дүгээр зүйлийн зохицуулалтаас үзэхэд хэлцэл хийх этгээд (цаашид "сонирхлын зөрчил бүхий этгээд" гэх)-ийг тодорхойлох замаар сонирхлын зөрчилтэй хэлцлийг тодорхойлж байна. Тодруулбал, (1) компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, (2) компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд²⁶ байна. Ингэхдээ тухайн этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол сонирхлын зөрчил бүхий этгээд гэж үзнэ. Үүнд:

Шигтгээ 1. Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцох харилцааны талаарх КтХ-ийн зохицуулалт

89.1.1.хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

89.1.2.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

89.1.3.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

89.1.4.хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

Дээрх сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ КтХ-ийн 92 дугаар зүйлд заасан журмыг баримлах бөгөөд сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэр гаргана гэж хуульчилжээ.

Мөндээрх журмыг зөрчсөн тохиолдолд шударга гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах талаар мөн хуулийн 93 дугаар зүйлд заасан байна. Тодруулбал, КтХ-

²⁵ Түмэнжаргалын Мэндсайхан, *Гэрээний эрх зүй*, (Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр, 2021), 5 дахь тал.

²⁶ Нэгдмэл сонирхолтой этгээд гэдэгт КтХ-ийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт зааснаар компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчийн (1) эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн, (2) эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү болон (3) тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талуудыг ойлгоно.



ийн 93 дугаар зүйлийн 93.6 дахь хэсэгт "Энэ хуулийн 93.3-т зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 92 дугаар зүйлд заасан журам зөрчсөн бөгөөд уг зөрчлийн талаар энэ хэлцлийг байгуулсан этгээд **мэдээгүй** болон **мэдэх боломжгүй** байсан нөхцөлд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцохгүй" гэжээ. Хуульд зааснаар гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах үндсэн нөхцөл нь тухайн гуравдагч этгээд сонирхлын зөрчил бүхий этгээдийг КтХ-ийн 92 дугаар зүйлд заасан хэлцэл хийх журмыг зөрчсөн эсэх талаар мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан бол түүний итгэлийг хамгаалж, хэлцлийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд, Эхний хэсэгт дурдсан илэрхий бүрэн эрхийн онолын үндсэн шинж болох сайн санааны зарчмын агуулгыг КтХ-ийн 93 дугаар зүйлийн 93.6 дахь хэсэгт хуульчилсан байна. Ингэснээр сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах үндэслэлийг бүрдүүлжээ. Харин энэ зохицуулалтын хүрээнд тусгай зохицуулалт бүхий гуравдагч этгээдийн итгэл хамгаалагдах эсэх асуудлыг дараагийн хэсэгт авч үзнэ.

б. Их хэмжээний хэлцэл, түүний эрх зүйн зохицуулалт

Их хэмжээний хэлцлийг КтХ-д тухайн хэлцлийн агуулга, гэрээний зүйлд үндэслэн тодорхойлсон байна. Тодруулбал, КтХ-ийн 87 дугаар зүйлд их хэмжээний хэлцэл гэдэгт дараах зүйлийг ойлгоно гэж хуульчилжээ. Үүнд:

Шугтгээ 2. КтХ-д заасан их хэмжээний хэлцлийн тухай ойлголт

87.1.Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно:

87.1.1.хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

87.1.2.компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

Дээрх зохицуулалтаас үзэхэд, их хэмжээний хэлцлийг тодорхойлохдоо (1) гэрээний зүйл, түүний үнийн дүнг компанийн сүүлийн балансын активын дүнтэй харьцуулах замаар, мөн (2) компанийн гаргах гэж буй энгийн хувьцаа, энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас, хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг компанийн өмнө гаргасан энгийн хувьцааны хувьтай харьцуулах замаар тодорхойлно гэжээ.

Харин их хэмжээний хэлцэл мөн эсэхийг КтХ-ийн 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь аудиторын²⁷ зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно гэж заасан. Мөн хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт "Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг

²⁷ Үүнд ямар аудитор байх талаар нарийвчлан зохицуулаагүй тул дотоод аудитор болон хөндлөнгийн аудитор аль аль нь хамаарах боломжтой байна.



төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгээгээр гаргана", мөн зүйлийн 88.2 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ" гэж зааснаас үзэхэд их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг гүйцэтгэх удирдлага бие даан гаргах эрхгүй байна.

Гэвч гүйцэтгэх удирдлага нь ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэргүйгээр их хэмжээний хэлцэл байгуулсан тохиолдолд гуравдагч этгээдийн итгэлийг хэрхэн хамгаалахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Харин зарим судлаачийн зүгээс их хэмжээний хэлцэл хийхтэй холбоотой хуульд заасан журам зөрчсөн буюу зохих этгээдийн зөвшөөрөлгүйгээр их хэмжээний хэлцэл хийсэн тохиолдолд арилжааны итгэлийг хамгаалах зарчмын дагуу КТХ-ийн §93.6-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах зохицуулалтыг хэрэглэх нь оновчтой гэж үзсэн.²⁸ Гэвч дээрх компанийн тухай хуулийн зохицуулалтад хамаарах харилцаанд Иргэний хуулийн 4 дүгээр зүйлд заасан "хуулийг төсөөтэй хэрэглэх зарчим"-ыг хэрэглэх боломжтой эсэх нь эргэлзээтэй юм.

3. Харьцуулсан судалгаа

Энэ хэсэгт арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчим (илэрхий бүрэн эрхийн онол)-ын агуулгыг хуульчилсан эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсууд болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид "ХБНГУ" гэх) болон Япон Улсын Иргэний хууль болон КТХ-ийн холбогдох зохицуулалтыг судлах болно.

а. ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-ын Иргэний хуулийн²⁹ 165 дугаар зүйлд "Төлөөлөгчөөр дамжуулан хийсэн эсхүл төлөөлөгчид хандсан хүсэл зоригийн илэрхийлэл нь төлөөлөгчийн гэрээ байгуулах эрх зүйн чадамж хязгаарлагдмал байсан шалтгаанаар хүчингүй болохгүй" гэж заасны дагуу төлөөлөгчийн хэлцэл хийх чадамжтай байсан эсэх нь гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй тул гуравдагч этгээдийн тухайн гэрээний хүчин төгөлдөр байдалд итгэх итгэлийг хамгаалсан хувийн эрх зүйн суурь зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Харин ХБНГУ-ын Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тухай хуульд³⁰ гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн хязгаарлалтын үйлчлэх хүрээг тодорхойлсон байна. Тодруулбал, тус хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "гүйцэтгэх удирдлагууд нь компанийг төлөөлөх бүрэн эрхийн хүрээнд компанийн дүрэмд заасан хязгаарлалт, эсхүл дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалтыг дагаж мөрдөх үүрэгтэй", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Гүйцэтгэх удирдлагуудын

²⁸ Ганхуягийн Давааням, өмнөх эшлэл 4.

²⁹ German Civil Code (1896), https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html#p0492 (last visited May.13, 2026).

³⁰ Act on Limited Liability Companies (1892), https://www.gesetze-im-internet.de/englisch_ambha/ (last visited May.13, 2026).



бүрэн эрхэд хийсэн хязгаарлалт нь гуравдагч этгээдийн хувьд эрх зүйн үр дагавар үүсгэхгүй. Энэ нь төлөөлөх бүрэн эрхийг тодорхой хэлцэл, хэлцлийн төрлөөр нь хязгаарласан, эсхүл тодорхой хугацаанд, тодорхой газрын хүрээнд хэрэгжүүлэхээр тогтоосон, мөн тодорхой хэлцэл хийхэд хувьцаа эзэмшигчийн эсхүл компанийн эрх бүхий этгээд (англ. organ)-ийн зөвшөөрөл шаардлагатай тохиолдол хамаарна" гэж заасны дагуу гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн дотоод хязгаарлалтын хүрээнд компанийг төлөөлж буй гүйцэтгэх удирдлагатай хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахаар хуульчилжээ.

Үүнээс үзэхэд, ХБНГУ-ын хувьд компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг тухайн компанийн дүрэм, компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн үндсэн дээр дотоод зохион байгуулалтын хүрээнд хязгаарлах боломжтой байна. Ийнхүү компани өөрийн удирдлагын эрх хэмжээг дотоод зохион байгуулалтын хүрээнд тогтоодог тул Монгол Улстай ижил КТХ-даа их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл зэргээр тухайлсан зохицуулалтгүй байна.

б. Япон Улс

Япон Улсын Иргэний хуулийн³¹ 109 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Гуравдагч этгээдэд бусдад төлөөлөх эрх олгосноо мэдэгдсэн этгээд нь уг этгээд төлөөлөх бүрэн эрхийнхээ хүрээнд гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэлд хариуцлага хүлээнэ. Гэхдээ гуравдагч этгээд төлөөлөх эрх олгогдоогүйг мэдсэн, мөн өөрийн хайхрамжгүй байдлын улмаас мэдээгүй бол үүнд хамаарахгүй" гэж заасны дагуу төлөөлөгчийн төлөөлөх эрхгүй байсныг мэдээгүй гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахаар заасан хэдий ч тухайн гуравдагч этгээд нь энэ талаар мэдсэн, эсхүл хайхрамжгүй хандсан бол үүнд хамаарахгүй гэж зааснаас үзэхэд уг зохицуулалтад илэрхий бүрэн эрхийн онолын үндсэн шинж болох сайн санааны зарчмын агуулгыг шингээсэн гэж үзэхээр байна.

Харин Япон Улсын КТХ-ийн³² 354 дүгээр зүйлд "Хэрэв хувьцаат компани нь компанийг төлөөлөх бүрэн эрхгүй гүйцэтгэх удирдлагыг ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч болон компанийн нэрийн өмнөөс төлөөлөх эрх бүхий албан тушаал мэтээр ойлгогдох бусад албан тушаалаар нэрлэсэн тохиолдолд, тухайн гүйцэтгэх удирдлагын үйлдэлд итгэсэн гуравдагч этгээдийн өмнө хувьцаат компани хариуцлага хүлээнэ" гэж заасан нь худалдааны тогтвортой байдлыг хадгалах зорилгын үүднээс хэлцлийн нэг тал төлөөлөх эрхтэй болохыг илэрхийлэхүйц гадаад нөхцөл байдлыг итгэн хүлээж авсныг хамгаалах гэсэн зорилготой бөгөөд тухайн итгэсэн этгээд нь шударга байх тохиолдолд гэм буруутай байсан ч хамгаалагдах боловч, илт болгоомжгүй хандсан тохиолдолд түүний итгэлийг хамгаалах боломжгүй болох юм.³³

³¹ Civil Code of Japanese (1896), <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3494/en> (last visited May.14, 2026).

³² Companies act of Japanese (2005), <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3206/en> (last visited May.14, 2026).

³³ Очи-ай Сэйчи, Компанийн эрх зүйн үндсэн ойлголт, (орч Р.Пүрэвбаатар, С.Сүхчулуун, Л.Отгондорж, А.Ган-Очир), 2017, 166 дахь тал.



4. Тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн этгээдийн чиг үүрэг болон итгэлийг хамгаалах зарчимтай холбоотой асуудал

Өмнөх хэсэгт Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн гадаад хязгаарлалтын төрөл /сонирхлын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний хэлцэл/, ойлголтыг гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах зарчимд хамаарах заалттай харьцуулан судаллаа. Ингэхдээ хуульд тусгайлсан зохицуулалт бүхий этгээд болох Банк, эрх бүхий хуулийн этгээдэд хуулиар олгосон бүрэн эрхийн талаар зохицуулалтыг өгүүллийн эхний хэсэгт дурдсан илэрхий бүрэн эрхийн онол болон КТХ-ийн зохицуулалттай харьцуулан судлах болно.

Банк, эрх бүхий хуулийн этгээд нь тухайн салбарын хууль тогтоомжид заасны дагуу дараах 2 чиг үүргийн хүрээнд харилцагчийн мэдээллийг цуглуулах бүрэн эрхтэй байна. Тодруулбал:

а. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд

Банк, эрх бүхий хуулийн этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнийг мэдээлэх чиг үүргийн хүрээнд өөрийн харилцагчийг таньж баталгаажуулах³⁴ (англ. *Know Your Customer*) үүргийг хуулиар хүлээдэг. Энэ үүргээ хэрэгжүүлэхдээ харилцагчаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах эрхтэй. Тодруулбал, харилцагчийг таньж баталгаажуулах үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль³⁵ (цаашид "МУТСТХ" гэх)-д дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

³⁴ Харилцагчийн таньж баталгаажуулах ажиллагаа гэдэгт хууль бус үйл ажиллагаанаас сэргийлэх зорилгоор санхүүгийн үйлчилгээ үзүүлэхдээ харилцагчийн мэдээллийг шалгаж, эрсдэлийг үнэлэх ажиллагааг ойлгоно.

³⁵ *Төрийн мэдээлэл эмхэтгэл*: 2013 он, №24.



Шигтгээ 3. Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт

5 дугаар зүйл. Харилцагчийг таньж мэдэх

5.1. Дараах тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр, нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан таньж мэдэх үүрэгтэй:

5.1.1. бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;

5.2. Энэ хуулийн 5.1-д заасны дагуу харилцагчийг таньж мэдэхийн тулд энэ хуулийн 4.1-д заасан этгээд дараах арга хэмжээ авна:

5.2.2. харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах;

5.2.4. харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;

5.2.5. харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол **түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж** уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;

Дээрх зохицуулалтаас үзэхэд, Банк, эрх бүхий хуулийн этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор харилцагч хуулийн этгээд /үүнд: компани хамаарна/-ийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг гаргуулах эрхтэй гэжээ. Өөрөөр хэлбэл, Банк, эрх бүхий хуулийн этгээд нь тухайн харилцагч компанийг төлөөлж буй этгээд нь төлөөлөх бүрэн эрхтэй эсэх, бусад этгээдийн оролцоо шаардлагатай эсэхийг тогтоох, мэдэх боломжтой гэж үзэхээр байна.

б. Зээлийн хувийн хэрэг хөтлөх чиг үүргийн хүрээнд

Банк, эрх бүхий хуулийн этгээд нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль³⁶ (цаашид "БЭБХЭМХМХШЗҮАТХ" гэх)-д заасны дагуу зээлийн үйлчилгээ үзүүлэхдээ харилцагч бүрд зээлийн хувийн хэрэг нээж, бүртгэл хөтөлдөг байна. Ингэхдээ зээлийн хувийн хэрэг нь дараах бүрдүүлбэртэй байна гэжээ. Үүнд:

³⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021 он, №27.

Шигтгээ 4. Зээлдэгчийн хувийн хэргийн бүрдүүлбэр

22.2.Зээлийн хувийн хэрэг дараах бүрдүүлбэртэй байна:

22.2.5.хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд бол орлогын талаарх мэдээлэл, хуульд заасны дагуу татварын байгууллагад тайлагнасан санхүүгийн тайлан;

22.2.9.үйл ажиллагааны ерөнхий нөхцөлд заасан болон зээлдүүлэгчээс зээл олгоход шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл, баримт бичиг.

Дээрх зохицуулалтаас үзэхэд, Банк, эрх бүхий хуулийн этгээд нь зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангах үүднээс зээл олгохдоо зээл хүссэн харилцагч компанийн татварын байгууллагад тайлагнасан санхүүгийн тайлан болон шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг гаргуулах эрхтэй байна. Үүнд тухайн харилцагч компанийг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх гэж байгаа эсэхтэй холбоотой мэдээллүүд хамаарах тул гүйцэтгэх удирдлага бие даан хэлцэл хийх эрхтэй эсэхийг мэдэх боломжтой байсан гэж үзэхээр байна.

Иймд компанийн гүйцэтгэх удирдлага нь Банк, эрх бүхий хуулийн этгээдтэй ТҮЗ, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэргүйгээр сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийсэн тохиолдолд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн хувьд итгэлийг хамгаалах зарчим үйлчлэхгүй. Учир нь шударга итгэл үнэмшил байгаагүй гэж үзэх үндэслэл бүрдэхээр байна. Тодруулбал, гуравдагч этгээд нь хэлцэлд сайн санааны үүднээс хандсан буюу гүйцэтгэх удирдлага компанийг төлөөлөх эрхгүй талаар мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бол түүний итгэлийг хамгаалах үндэслэл бүрдэх талаар өмнөх хэсэгт дурдсан билээ.

Мөн КтХ-ийн \$93.6 дахь хэсэгт компанийг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх гэж байгаа талаар мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бол түүнд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах үүднээс тухайн хэлцлийг хүчинтэй гэж үзэхээр заасан.

Гэвч тусгайлсан зохицуулалт бүхий гуравдагч этгээд буюу БЭБХЭ-ийн хувьд үүнийг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан гэж үзэх үндэслэлгүй юм. Учир нь МУБТСТтХ болон БЭБХЭМХМХШЗҮАтХ-аар БЭБХЭ нь харилцаж буй байгууллагыг таньж баталгаажуулах, хувийн хэрэг хөтлөх бүрэн эрхийн хүрээнд тухайн байгууллагыг төлөөлж буй гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх нь хязгаарлагдсан эсэх талаар мэдэх боломжтой байсан гэж үзнэ.

Хэдий БЭБХЭ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд харилцагч компанийг төлөөлж буй гүйцэтгэх удирдлага нь төлөөлөх эрхтэй байсан эсэхийг мэдэх боломжтой боловч БЭБХЭ-ийн хуулиар хүлээсэн чиг үүрэг нь хэлцлийн хүчин төгөлдөр байдалд бус мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон харилцагчийн бүртгэл хөтлөх зорилгод чиглэдэг тул харилцагч компанийг хэлцэл хийх журмыг зөрчсөн эсэхэд анхаарал хандуулаагүй байх боломжтой юм.

Иймд харилцагч компани нь дээрх нөхцөл байдлыг ашиглан хэлцэлд хайнга хандах, хуульд заасан хэлцэл хийх журмыг зөрчиж, хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах замаар гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөх арга, хэрэгсэл болгон ашиглах эрсдэлтэй юм.



III. ДҮГНЭЛТ

Арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчим нь илэрхий бүрэн эрхийн онолтой шууд холбоотой байдаг. Учир нь компани нь өөрийгөө төлөөлөх боломжгүй, хиймэл этгээд гэж үздэг тул түүнийг төлөөлөх этгээд байх бөгөөд тухайн этгээдийн компанийг төлөөлөх бүрэн эрхийн хязгаарлалт нь гуравдагч этгээдтэй хийсэн хэлцлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөх боломжтой байна. Иймд тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын төлөөлөх бүрэн эрхэд итгэж хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах шаардлага үүсжээ.

Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд нь ихэвчлэн гүйцэтгэх удирдлага байдаг тул түүний төлөөлөх бүрэн эрхийн хүрээнд (1) хүлцсэн бүрэн эрх, (2) илэрхий бүрэн эрх гэсэн 2 онолын ойлголт байна. Хүлцсэн бүрэн эрх нь төлөөлүүлж буй этгээд өөрийг нь төлөөлөх эрхгүй этгээд гуравдагч этгээдийн өмнө төлөөлж буй талаар мэдсэн хэдий ч энэ талаар гуравдагч этгээдэд мэдэгдээгүй буюу эс үйлдэхүй гаргахыг хэлнэ. Харин илэрхий бүрэн эрх гэдэг нь төлөөлүүлэгч нь өөрийг нь төлөөлөх эрхгүй этгээдийг гуравдагч этгээдийн өмнө төлөөлөх эрхтэй гэж ойлгохоор нөхцөл бүрдүүлснийг хэлэх бөгөөд энэхүү судалгааны хүрээнд илэрхий бүрэн эрхийн онолын агуулга дээр тулгуурлан Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд судалгаа хийлээ.

Илэрхий бүрэн эрхийн онол нь бодит байдлаас зөрүүтэй гадаад илэрхийлэл бүрдсэн, энэ нь төлөөлүүлэгчээс шалтгаалсан бөгөөд уг гадаад илэрхийлэлд гуравдагч этгээд шударгаар итгэсэн буюу энэ талаар мэдээгүй, мэдэх боломжгүй байсан зэрэг үндсэн шинжийг агуулдаг. Тус онолын зорилго нь гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах, бодит байдлаас зөрүүтэй гадаад илэрхийллийн улмаас үүсэх хариуцлага хүлээх этгээдийг тодорхойлох болон эрх зүйн харилцааны тогтвортой байдлыг хангахад чиглэдэг байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд (1) хүлцсэн бүрэн эрхийн онолтой холбоотой агуулгыг Иргэний хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт заасан бол (2) илэрхий бүрэн эрхийн онолтой холбоотой агуулгыг КтХ-ийн зарим хэсэгт тухайлан зохицуулсан байна. Тодруулбал, КтХ-ийн 12 дугаар бүлэгт сонирхлын зөрчилтэй хэлцлийг компанийн гүйцэтгэх удирдлага бие даан хийх эрхгүй бөгөөд тус хэлцлийг ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ын шийдвэр дээр үндэслэж хийнэ гэж заасан. Харин мөн хуулийн 93 дугаар зүйлийн 93.6 дахь хэсэгт гуравдагч этгээд энэ талаар мэдээгүй, мэдэх боломжгүй байх үедээ тухайн этгээдтэй хэлцэл хийсэн бол тухайн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэхгүй гэж заасан нь гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах зохицуулалт болсон.

Гэвч КтХ-ийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийн хувьд гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг хуульчлаагүй бөгөөд зарим судлаачийн үзсэнээр дээрх 93.6 дахь хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийн зохицуулалтыг их хэмжээний хэлцлийн хүрээнд хэрэглэх нь зүйтэй гэж үзжээ.

Харин тус төсөөтэй зохицуулалтыг төсөөтэй хэрэглэхтэй холбоотой асуудал нь энэхүү өгүүллийн хүрээнд талаар дэлгэрүүлэн судлаагүй болно. Иймд цаашид



дээрх сонирхлын зөрчилтэй хэлцлийн зохицуулалтыг, их хэмжээний хэлцэлтэй холбоотой маргаанд хэрэглэх боломжтой эсэх талаар иргэний эрх зүйн "хуулийг /эрх зүйг/ төсөөтэй хэрэглэх" зарчим болон шүүхийн хууль хэрэглээний практикийн хүрээнд дэлгэрүүлэн судлах боломжтой юм.

Харьцуулсан судалгааны хүрээнд ХБНГУ болон Япон Улсуудын хувьд Иргэний хууль болон КтХ-даа илэрхий бүрэн эрхийн онолын агуулгыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай төсөөтэй байдлаар хуульчилсан байна. Тодруулбал, илэрхий бүрэн эрхийн онолын нэг үндсэн шинж болох шударга итгэл үнэмшил /сайн санаа/-ийг гол шалгуур болгосныг анхаарах нь зүйтэй.

Гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалахтай холбоотой илэрхий бүрэн эрхийн онол болон КтХ-ийн зохицуулалтад тулгуурлан тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн этгээд болох БЭБХЭ-ийн чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд судалж үзэхэд, БЭБХЭ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон харилцагчийн бүртгэл хөтлөх чиг үүргийн хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй этгээдийн мэдээллийг цуглуулах бүрэн эрхтэй байхаар хуульчилжээ. Иймд компанийн гүйцэтгэх удирдлага нь БЭБХЭ-тэй сонирхлын зөрчилтэй хэлцэл, эсхүл их хэмжээний хэлцэл хийхдээ зохих этгээдийн шийдвэргүйгээр /зөвшөөрөл аваагүй/ буюу хуульд заасан шаардлагыг зөрчсөн ч гуравдагч этгээд болох БЭБХЭ-ийн итгэлийг хамгаалах боломжгүй болох эрсдэлтэй байна.

Учир нь илэрхий бүрэн эрхийн онолын нэг үндсэн шинж нь гуравдагч этгээд хэлцэлд төлөөлж буй этгээдийг төлөөлөх бүрэн эрхгүй талаар мэдээгүй, мэдэх боломжгүй байх ёстой бөгөөд КтХ-д мөн энэ агуулгаар хуульчилсан. Харин БЭБХЭ нь хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд энэ талаар мэдэх боломжтой байсан гэж үзэхээр байна. Гэвч БЭБХЭ-ийн харилцагчийг танин баталгаажуулах ажиллагааны зорилго нь харилцагч компанийн зохион байгуулалтын талаар мэдээллийг авах бус (1) мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, (2) санхүүгийн үйлчилгээ авч буй этгээдийн бүртгэл хөтлөхөд чиглэдэг болохыг анхаарч үзэх нь зүйтэй.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна:

1) БЭБХЭ-д хуулиар олгосон бүрэн эрхийн ач холбогдлыг илүү тодруулах үүднээс БЭБХЭ-ийн үйл ажиллагааны гол хууль буюу Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд "харилцагч нь хуулийн этгээд /компани/ бол түүнийг төлөөлж буй этгээд нь төлөөлөх эрхтэй эсэх, бусад этгээдийн зөвшөөрөл шаардлагатай эсэхийг тодруулах" гэх агуулга нэмж оруулах.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Иргэний хууль, 2002 он.
2. Компанийн тухай хууль, 2011 он.
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 он.
4. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, 2021 он.
5. Улсын дээд шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоол.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Даваасүрэнгийн Наранчимэг, *Иргэний эрх зүй – I*, 2023 он.
2. Түмэнжаргалын Мэндсайхан, *Гэрээний эрх зүй*, Анхны хэвлэл, 2021 он.
3. Жаргалсайханы Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй – II гэрээний үүрэг*, 2022 он.
4. Очи-ай Сэйчи, *Компанийн эрх зүйн үндсэн ойлголт*, (орч Р.Пүрэвбаатар, С.Сүхчулуун, Л.Отгондорж, А.Ган-Очир), 2017 он.
5. Ганхуягийн Давааням, "Гүйцэтгэх удирдлагын итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхэд хийсэн дотоод хязгаарлалт, түүний эрх зүйн үр дагавар" *Эрх зүй сэтгүүл*, №3 (59), 2022 он.
6. Ганхуягийн Давааням, "Иргэний хуулийн 65.1 дэх илэрхий бүрэн эрхийн ойлголт, түүний хэрэглээ", *Эрх зүй сэтгүүл*, №4 (64), 2023 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. German Civil code, 1896.
2. Act on Limited Liability Companies, 1892.
3. Civil Code of Japanese, 1896.
4. Companies act of Japanese, 2005.
5. Victoria Barnes and James Oldham, "The Legal Foundations of Apparent authority", *Journal of Corporation law* 44, no4, 2018.
6. Carole Murray, David Holloway and Daren Timson-Hunt, *Schmitthoff's Export Trade*, 11th ed, 2007.
7. Roy Goode and Ewan McKendrick, *Commercial law*, 6th ed, 2020.

Б. Герман хэл дээр

1. MTRLegal: Rechtsscheintheorie, 2025, <https://www.mtrlegal.com/wiki/rechtsscheintheorie/>.

4. Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. ХБНГУ-ын эрх зүйн мэдээллийн албан ёсны цахим хуудас: <https://www.gesetze-im-internet.de/>.
3. Япон Улсын хуулийн орчуулгын цахим хуудас: <https://www.japaneselawtranslation.go.jp/en>.
4. "MTRLegal" ХБНГУ-ын эрх зүйн мэдээллийн цахим хуудас: <https://www.mtrlegal.com/>.



Article

The principle of protect to faith in commercial law and interrelationship of special regulations with functions of legal entities

JAVKHLANT Luvsanbat*

Abstract: Within the framework of this article, the objective is to examine the legal regulation of Mongolia concerning the protection of the reliance of third parties who have entered into transactions with a company's executive directors, in circumstances where the directors' authority to conclude such transactions has been restricted, and to compare this regulation with the doctrine concept of apparent authority. In this regard, the general notion of a third party is further specified, and consideration is given to whether the statutory functions of banks and other authorized legal entities may impede the protection of such reliance.

This is due to the fact that banks and authorized legal entities, within the scope of their statutory functions, are vested with the authority to collect client information, which may potentially conflict with the essential characteristics of the doctrine of apparent authority

Keywords: Doctrine of apparent authority, executive director, limitation of authority to representation, bank, authorized legal entity.

* Researcher of the Administrative law sector of Judicial academy under the Supreme court of Mongolia, Master's degree candidate of School of Law, National University of Mongolia.